

ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасыг зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлох, түүнд тавигдах шаардлагыг тогтоох, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Үнэт цаасыг барьцаалахтай холбогдсон харилцаанд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан үнэт цаас барьцаалахтай холбогдох журмыг дагаж мөрдөнө.

ХОЁР. ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1. Үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээнд дараах этгээдүүд (цаашид “зээлдүүлэгч” гэх) оролцоно. Үүнд:
 - 2.1.1. Үнэт цаасны мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны эрхтэй, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй үнэт цаасны компани;
 - 2.1.2. Хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сан.
- 2.2. Зээлдүүлэгч нь энэ журмын 2.1.1-т заасан этгээд байх тохиолдолд тухайн үнэт цаасны компани нь зээлдүүлэх үйлчилгээг харилцагчдад үзүүлэхдээ өөрийн нэр дээрх үнэт цаасыг зээлдүүлэх бөгөөд энэ тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын төвлөрсөн бүртгэлд өөрчлөлт оруулахгүй байж болно.
- 2.3. Зээлдүүлэгч нь энэ журмын 2.1.2-т заасан этгээд байх тохиолдолд тухайн этгээдийн үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой зээлдүүлэх үнэт цаас болон барьцаанд тавих хөрөнгийг шилжүүлэх, бүртгэх, хадгалах, талуудыг мэдээллээр хангах, зээлдүүлэгчийн өмнөөс эрх, үүргийг хэрэгжүүлэх ажиллагааг кастодианы үйл ажиллагаа эрхлэгч этгээд хэрэгжүүлэх бөгөөд энэ тохиолдолд зээлдэгч нь тухайн кастодианы харилцагч байна.
- 2.4. Үнэт цаас зээлэх үйлчилгээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д заасан этгээд (цаашид “зээлдэгч” гэх) оролцоно.
- 2.5. Зээлдүүлэгч нь Засгийн газар, аймаг, нийслэлийн үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагын бонд, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын I, II ангилалд бүртгэлтэй компанийн хувьцаа, нээлттэй арилжаалагддаг компанийн бонд, хамтын сангийн нэгж эрх, үнэт цаасны зах зээлд арилжаалахаар гаргасан хадгаламжийн сертификатаас бусад үнэт цаасыг зээлдүүлэхгүй.
- 2.6. Зээлдүүлэгч нь зээлдэгчийг таньж мэдэх, түүний санхүүгийн чадамж, барьцаа хөрөнгө, хөрөнгө оруулалтын туршлагыг хянаж үзсэний үндсэн дээр үнэт цаасаа зээлдүүлэх эсэх шийдвэрийг гаргана.
- 2.7. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээнд оролцож буй талууд “Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх гэрээ” (цаашид “гэрээ” гэх)-г Олон улсын үнэт цаас зээлдүүлэх холбоо (ISLA)-ны зарчмуудад тулгуурлан харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулах бөгөөд уг гэрээнд дараах зүйлсийг тусгана:

- 2.7.1. талуудын хууль ёсны нэр, хаяг, хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар болон бусад шаардлагатай мэдээлэл;
 - 2.7.2. зээлдүүлэх үнэт цаасны төрөл, тоо хэмжээ, төрөл тус бүрийн болон нийт үнийн дүн;
 - 2.7.3. зээлийн хугацаа;
 - 2.7.4. барьцаа хөрөнгийн болон барьцаа хөрөнгө үнэт цаас байх тохиолдолд хорогдуулалтын хувь хэмжээ;
 - 2.7.5. үйлчилгээний шимтгэлийн хувь хэмжээ, төлөх давтамж, тооцож эхлэх хугацаа;
 - 2.7.6. барьцаанд тавьсан мөнгөн хөрөнгийг хадгаламжид байршуулах тохиолдолд хүү тооцож эхлэх болон дуусах өдөр;
 - 2.7.7. талуудын эрх, үүрэг, хариуцлага;
 - 2.7.8. гэрээний зөрчил үүсэх нөхцөл, үүссэн тохиолдолд авах арга хэмжээ;
 - 2.7.9. бусад.
- 2.8. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл аль нэг талын санаачилгаар, талууд зөвшилцөлд хүрснээр цуцалж болно.
 - 2.9. Зээлдүүлэгч зээлдүүлэх үнэт цаасыг зээлдэгчид шилжүүлж, зээлдэгч барьцааг зээлдүүлэгчид шилжүүлсэн тохиолдолд гэрээ хүчин төгөлдөр болно.
 - 2.10. Зээлдэгч нь зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшинд суурилан үнэт цаасыг эргэн төлөх баталгаа болгон барьцаа хөрөнгийг байршуулах бөгөөд барьцаа хөрөнгө нь бэлэн мөнгө, эсхүл энэ журмын 2.5-д заасан үнэт цааснаас бүрдэнэ.
 - 2.11. Энэ журмын 2.9-д заасан барьцаа хөрөнгө нь мөнгөн хэлбэртэй байх тохиолдолд зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханштай тэнцүү, эсхүл үнэт цаас хэлбэртэй байх тохиолдолд зээлж авах үнэт цаасны зах зээлийн ханшнаас дээш дүнтэй байх бөгөөд энэ тохиолдолд хорогдуулалтын хувь хэмжээг гэрээнд тусгана.
 - 2.12. Зээлдэгч болон зээлдүүлэгч хоорондоо тохиролцсон бол зээлдэгч нь зээлээр авсан үнэт цаасаа буцаан олгох хүртэл барьцаанд байгаа бэлэн мөнгийг богино хугацаатайгаар банкны мөнгөн хадгаламжид хадгалуулж болох бөгөөд хадгаламжийн хүүгийн орлогын хэмжээ, төлбөрийн нөхцөлийг талууд тохиролцсоны үндсэн дээр гэрээнд тодорхой заана.
 - 2.13. Зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгөд авах үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан үнэт цаас барьцаалахтай холбогдох журмын дагуу барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн санд бүртгүүлж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар тусгаарлуулах ажиллагааг гүйцэтгүүлнэ.
 - 2.14. Зээлдэгч болон зээлдүүлэгч нь шаардлагатай тохиолдолд гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө гэрээг цуцлах, үнэт цаасыг буцаан шилжүүлэх, эргүүлэн дуудах болон барьцаа хөрөнгийг солихтой холбоотой эрх, үүргийг гэрээнд тусгаж болно.
 - 2.15. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагаар дамжуулан үнэт цаас зээлэх тохиолдолд зээлдүүлсэн үнэт цаасны ногдол ашиг, үнэт цаасны хүү болон саналын эрх зэрэг үнэт цаасны эзэмшилтэй холбоотой тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх эрх гэрээний хугацаанд зээлдэгчид шилжих бөгөөд зээлдэгч нь тухайн өгөөжийг талуудын гэрээгээр тохиролцсон хугацаанд зээлдүүлэгчид олгоно.
 - 2.16. Талууд өөрөөр тохиролцоогүй бол зээлдэгч нь зээлсэн үнэт цаастай холбоотой аливаа шимтгэл, хураамж болон бусад холбогдох зардлыг хариуцах бөгөөд зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгөтэй холбогдох зардлыг хариуцна.

- 2.17. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулсан нарийвчилсан журмыг арилжаа эрхлэх байгууллага тогтоож, уг журмыг Хороогоор батламжлуулна.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 3.1. Зээлдүүлэгч нь зээлдүүлэх үнэт цаасны зах зээлийн ханшинд үндэслэн барьцаа хөрөнгийн үнэлгээг өдөр тутам тооцох бөгөөд дутагдал гарсан тохиолдолд нэмэлт барьцаа байршуулахыг зээлдэгчээс шаардах, илүүдэл гарсан бол илүү хэсгийг зээлдэгчид буцаан шилжүүлнэ.
- 3.2. Зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд зээлдүүлэгч нь барьцаа хөрөнгийг зарж борлуулах, түүнээс олсон орлогыг зээлдүүлсэн үнэт цаасыг дахин худалдан авах болон зээлдэгчээс төлөгдөх ёстой бусад төлбөр, хураамжийг барагдуулахад ашиглана.
- 3.3. Энэ журмын 3.2-т заасны дагуу зээлдүүлсэн үнэт цаасыг дахин худалдан авах тохиолдолд гарах зардал нь барьцаа хөрөнгийн ханшнаас давсан бол зээлдэгч зөрүү төлбөрийг төлөх бөгөөд бүх төлбөр, үүргийг бүрэн барагдуулсны дараа үлдэгдэл барьцаа хөрөнгийг зээлдэгчид буцаан олгоно.
- 3.4. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн зээлдүүлж болох үнэт цаасны нийт хэмжээ нь тухайн сангийн нийт активын 30 хувиас хэтрэхгүй байна.

ДӨРӨВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Зээлдүүлэгчийн эрх, үүрэг

- 4.1.1. зээлийн эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээг өдөр бүр тооцоолох;
- 4.1.2. барьцаа хөрөнгийн анх байршуулсан хэмжээ шаардлагатай хэмжээнээс бага болсон тохиолдолд зээлдэгчээс нэмэлт барьцаа байршуулахыг шаардах;
- 4.1.3. барьцаа хөрөнгийн анх байршуулсан хэмжээ шаардлагатай хэмжээнээс их болсон тохиолдолд зээлдэгчид барьцааны тодорхой хэсгийг буцаан шилжүүлэх;
- 4.1.4. гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд холбогдох байгууллагад тухай бүр мэдэгдэх;
- 4.1.5. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх боломжтой үнэт цаасны нэгдсэн мэдээллээр оролцогч талуудыг хангах;
- 4.1.6. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой гэрээ, заавар, баримт бичиг болон холбогдох бусад бүртгэлийг цахим болон цаасан хэлбэрээр таваас доошгүй жил хадгалах;
- 4.1.7. зээлдэгч зээлсэн үнэт цаасыг буцаан шилжүүлсэн тохиолдолд барьцаа хөрөнгийг буцаан олгох.

4.2. Зээлдэгчийн эрх, үүрэг

- 4.2.1. барьцаанд тавьсан үнэт цаасны хүү, ногдол ашгийн орлого болон саналын эрх зэрэг үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх;
- 4.2.2. зээлж авсан үнэт цаасыг эргэн төлөх баталгаа болгон зээлдүүлэгчийн шаардсан барьцаа хөрөнгийг гэрээнд заасны дагуу байршуулах;
- 4.2.3. шаардлагатай барьцаа хөрөнгийн хэмжээ анх байршуулсан барьцаа хөрөнгийн ханшнаас буурсан тохиолдолд нэмэлт барьцаа хөрөнгө байршуулах, илүү гарсан тохиолдолд барьцааны тодорхой хэсгийг буцаан шилжүүлэхийг зээлдүүлэгчээс шаардах;

- 4.2.4. талуудын харилцан тохиролцсон мэдээллийг зээлдүүлэгчид гаргаж өгөх;
- 4.2.5. гэрээ дуусгавар болох эсхүл аль нэг талын санаачилгаар цуцлах үед зээлж авах үнэт цаасыг зээлдүүлэгчид буцаан шилжүүлэх;
- 4.2.6. үнэт цаасны зээлийн барьцаа хөрөнгөнд байгаа аливаа үнэт цаасыг давхар барьцаанд ашиглахгүй байх.

4.3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын эрх, үүрэг

- 4.3.1. талуудын хооронд байгуулсан гэрээний мэдээллийг үндэслэн үнэт цаасны өмчлөх эрхийг аливаа хүндрэл, чирэгдэлгүйгээр шуурхай байдлаар шилжүүлэх;
- 4.3.2. талуудын хооронд байгуулсан гэрээний мэдээллийг үндэслэн зээлдэгчийн барьцаанд байршуулсан үнэт цаасыг тусгаарлах, чөлөөлөх.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

5.1. Зээлдүүлэгч нь дараах мэдээллийг Хороонд цахимаар хүргүүлнэ. Үүнд:

- 5.1.1. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой оролцогч талууд хооронд байгуулсан гэрээний хуулбар;
- 5.1.2. үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээний хүрээнд хийгдсэн хэлцлийн сар бүрийн мэдээллийг дараа сарын 5-ны дотор;
- 5.1.3. үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотой үйлчилгээний шимтгэлийн хувь, түүнд өөрчлөлт орсон бол шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор;
- 5.1.4. зээлдүүлэгч нь зээлдэгчийг төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр;
- 5.1.5. үнэт цаас зээлдүүлэх гэрээтэй холбоотой маргаан шүүх, хяналтын байгууллагад шилжсэн тохиолдолд тухай бүр.

~oOo~